



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/58/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2023 .02.17</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа Утас: 89499922 Цахим хаяг: enkhtuyad@gmail.com Аудитор Д.Цэцэгмаа Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5.Аудитын илрүүлэлт	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

2023.08.17 № 2/42

танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д Энгийн, хувилбар сургалтын хэлбэрээр сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэсний дагуу Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн баталснаар БШУ-ны сайдын 2022.05.12-ны А/170 тушаалаар "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал"-ыг баталсан байна.

Дээрх өөрчлөлттэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн, орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

005020224

D/2023-A4 Alban toot doc

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>55,017,597.83</u>	<u>103,503,462.43</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	52,630,417.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	52,630,417.00
3121	Төгрөг	00.00	52,630,417.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	52,630,417.00
33	АВЛАГА	18,460.31	1,018,459.31
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	18,460.31	1,018,459.31
35	БАРАА МАТЕРИАЛ	54,999,137.52	49,854,586.12
351	Түүхий эд материал	2,876,700.00	682,900.00
35130	Эм боох материал	2,876,700.00	682,900.00
354	Хангамжийн материал	52,122,437.52	49,171,686.12
35410	Бичиг хэргийн материал	4,371,269.00	3,499,169.00
35420	Аж ахуйн материал	37,099,815.00	34,913,943.00
35450	Барилгын засварын материал	4,134,000.00	3,459,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,517,353.52	7,299,574.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>363,080,124.86</u>	<u>361,318,511.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	363,080,124.86	361,318,511.50
392	Биет хөрөнгө	352,661,124.86	350,927,011.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	352,567,450.00	352,567,450.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,081,753.28	-24,939,138.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,410,972.73	37,232,372.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,189,017.82	-17,806,248.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,470,464.01	21,470,464.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,607,296.34	-17,657,900.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	409,400.00	409,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-319,094.44	-349,387.84
393	Биет бус хөрөнгө	10,419,000.00	10,391,499.96
39301	Програм хангамж	425,000.00	425,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-177,500.04
39303	Бусад биет бус хөрөнгө	10,144,000.00	10,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>418,097,722.69</u>	<u>464,821,973.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>395,832.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	395,832.00	00.00
413	Өглөг	395,832.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	395,832.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>417,701,890.69</u>	<u>464,821,973.93</u>

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	417,701,890.69	464,821,973.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,925,265.00	60,925,265.00
51101	Өмч: - төрийн	60,925,265.00	60,925,265.00
512	Хуримтлагдсан үр дүн	-2,499,656.37	44,620,426.87
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,499,656.37	-2,499,656.37
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	47,120,083.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	359,276,282.06	359,276,282.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	418,097,722.69	464,821,973.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	371,067,772.00	484,919,692.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	476,750.00	6,821,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	476,750.00	6,821,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ	00.00	6,821,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ	476,750.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	370,591,022.00	478,098,292.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	316,069,900.00	415,583,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	415,583,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	316,069,900.00	0,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,669,040.00	15,983,292.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,669,040.00	15,983,292.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,852,082.00	46,532,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,852,082.00	46,532,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	363,589,293.51	437,799,608.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	363,589,293.51	437,799,608.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314,143,521.51	416,646,964.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,848,171.00	271,809,420.00
210101	Үндсэн цалин	204,504,456.00	250,580,895.00
210104	Урамшуулал	18,343,715.00	9,671,521.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,557,004.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,311,515.00	33,338,549.00

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	20,060,900.00	22,993,802.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,228,482.00	2,718,093.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,783,460.00	2,174,473.00
210204	Ажилгүйдлийн даатгал	378,374.00	489,539.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,860,299.00	4,962,642.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,353,082.00	33,826,411.00
210301	Гэрэл, цахилгаан	1,798,332.00	3,492,011.00
210302	Түлш, халаалт	28,404,750.00	29,914,400.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	420,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,456,613.00	12,469,301.40
210401	Бичиг хэрэг	1,018,200.00	3,870,750.00
210402	Тээвэр, шатахуун	1,637,400.00	2,188,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,189,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	35,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	95,132.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,111,381.00	1,909,000.00
210408	Бараа материал акталсны зардал	370,500.00	4,501,251.40
2105	Нормативт зардал	13,633,700.00	50,131,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,195,350.00	2,193,800.00
210502	Хоол, хүнс	12,279,350.00	46,528,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	159,000.00	1,408,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,001,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	1,001,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	98,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	98,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	588,000.00	1,106,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,000.00	1,106,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,853,440.51	13,465,853.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,882,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	642,500.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,210,940.51	10,583,013.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,445,772.00	21,152,644.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,769,040.00	19,696,681.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,118,170.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,550,870.00	15,983,292.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	3,713,389.00

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,455,963.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,455,963.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,676,732.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,676,732.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,478,478.49	47,120,083.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7,478,478.49	47,120,083.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	370,591,022.00	478,098,292.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	370,591,022.00	478,098,292.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	316,069,900.00	415,583,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	415,583,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	316,069,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,669,040.00	15,983,292.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,669,040.00	15,983,292.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,852,082.00	46,532,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,852,082.00	46,532,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	364,826,422.00	423,467,875.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	364,826,422.00	423,467,875.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315,380,650.00	402,315,231.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,848,171.00	273,205,251.00
210101	Үндсэн цалин	181,764,627.00	208,553,633.00
210102	Нэмэгдэл	21,834,855.00	49,569,779.00
210104	Урамшуулал	19,248,689.00	4,695,637.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	10,386,202.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,311,515.00	33,338,549.00
210201	Тэтгэврийн даатгал	20,159,471.00	23,050,221.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,109,329.00	2,718,095.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,760,011.00	2,174,474.00
210204	Ажилгүйдлийн даатгал	428,370.00	488,747.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,854,334.00	4,907,012.00

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,353,082.00	33,826,411.00
210301	Гэрэл, цахилгаан	1,798,332.00	3,492,011.00
210302	Түлш, халаалт	28,404,750.00	29,914,400.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	420,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,113,532.00	00.00
210401	Бичиг хэрэг	605,500.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,491,200.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	992,700.00	00.00
210404	Ном, хэвлэл	858,600.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,132.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,030,400.00	00.00
2105	Нормативт зардал	18,405,050.00	46,528,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,100,300.00	00.00
210502	Хоол, хүнс	12,279,350.00	46,528,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,025,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,175,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	4,175,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	98,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	98,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	817,300.00	1,106,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	231,300.00	1,106,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,259,000.00	13,809,890.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,360,000.00	9,879,890.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,899,000.00	3,930,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,445,772.00	21,152,644.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,769,040.00	19,696,681.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,118,170.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,550,870.00	15,983,292.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	3,713,389.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,455,963.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,455,963.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,676,732.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,676,732.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,764,600.00	54,630,417.00

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	5,764,600.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,764,600.00	2,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,764,600.00	2,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,764,600.00	2,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,764,600.00	-2,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	52,630,417.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	52,630,417.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-9,978,134.86	410,223,412.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-9,978,134.86	410,223,412.20
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,478,478.49	7,478,478.49
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-2,499,656.37	417,701,890.69
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-2,499,656.37	417,701,890.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	-2,499,656.37	417,701,890.69
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	47,120,083.24	47,120,083.24
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,925,265.00	359,276,282.06	44,620,426.87	464,821,973.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	462,115,000.00	408,028,620.00	54,086,380.00	88.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,115,000.00	408,028,620.00	54,086,380.00	88.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,399,600.00	404,315,231.00	54,084,369.00	88.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,040,500.00	273,205,251.00	44,835,249.00	85.90
210101	Үндсэн цалин	246,399,300.00	208,553,633.00	37,845,667.00	84.64
210102	Нэмэгдэл	50,997,100.00	49,569,779.00	1,427,321.00	97.20
210104	Урамшуулал	10,191,300.00	4,695,637.00	5,495,663.00	46.07
210105	Гэрээт ажлын хөлс	10,452,800.00	10,386,202.00	66,598.00	99.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,076,500.00	33,338,549.00	5,737,951.00	85.32
210201	Тэтгэврийн даатгал	26,186,900.00	23,050,221.00	3,136,679.00	88.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,222,400.00	2,718,095.00	504,305.00	84.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,577,900.00	2,174,474.00	403,426.00	84.35
210204	Ажилгүйдлийн даатгал	644,500.00	488,747.00	155,753.00	75.83
210205	Эрүүл мэндийн даатгал	6,444,800.00	4,907,012.00	1,537,788.00	76.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,987,600.00	34,326,411.00	661,189.00	98.11
210301	Гэрэл, цахилгаан	4,612,700.00	3,492,011.00	1,120,689.00	75.70
210302	Түлш, халаалт	29,954,900.00	29,914,400.00	40,500.00	99.86
210303	Цэвэр, бохир ус	420,000.00	420,000.00	0.00	100.
2105	Нормативт зардал	48,873,100.00	46,528,800.00	2,344,300.00	95.20
210502	Хоол, хүнс	48,873,100.00	46,528,800.00	2,344,300.00	95.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	1,106,330.00	3,670.00	99.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,106,330.00	3,670.00	99.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15811900.00	15809890.00	2,010.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,881,900.00	11,879,890.00	2,010.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,930,000.00	3,930,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3715400.00	3713389.00	2,011.00	99.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,715,400.00	3,713,389.00	2,011.00	99.95

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,715,400.00	3,713,389.00	2,011.00	99.95
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	462,115,000.00	460,659,037.00	1,455,963.00	99.68
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	415,583,000.00	415,583,000.00	0.00	100.0
131001	Урсгал үйл ажиллаганы санхүүжилт		415,583,000.00	415,583,000.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	415,583,000.00		(415,583,000.00)	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,532,000.00	45,076,037.00	1,455,963.00	96.87
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	180.00	152.00	28.00	84.44
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	180.00	152.00	28.00	84.44
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.00	18.00	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	12.00	12.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалант сумын Цэцэрлэгийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд зааснаар “бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж зорилго зорилтыг тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :

- Засгийн газрын 2021.12.21-ны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсан

- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУ-ны сайдын 2022 оны “Заавар батлах тухай” А/170 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар аргачлал”
- БШУ-ны сайд, ЭМС-ын 2022 оны А/235, А/340 дугаар хамтарсан “Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай тушаал
- Мөн Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолууд
- БШУ-ны сайдын 2022 оны А/430 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журам,
- БШУ-ны сайдын 2022 оны А/500 тоот тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал олгох журам

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Харин Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д зааснаар Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг БШУЯ-ны БЕГ-т нэгтгэгдэж, орон нутгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс БНА-2023/58/НА-СТА-ТШЗ

2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 464,822.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 46,724.3 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,017.6	103,503.5	48,485.9
Мөнгөн хөрөнгө	-	52,630.4	52,630.4
Авлага	18.5	1,018.5	1,000.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	54,999.1	49,854.6	(5,144.6)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	363,080.1	361,318.5	(1,761.6)
Үндсэн хөрөнгө	413,427.3	422,248.7	8,821.4
Хуримтлагдсан элэгдэл	(50,347.2)	(60,930.2)	(10,583.0)
Нийт хөрөнгө	418,097.7	464,822.0	46,724.3
Өр төлбөр	395.8	-	(395.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	417,701.9	464,822.0	47,120.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	418,097.7	464,822.0	46,724.3

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 52,630.4 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 49,854.6 мянган төгрөг болж 5,144.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд нийт 57,955.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 58,599.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 4,501.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 422,248.7 мянган төгрөг болж 8,821.4 мянган төгрөгөөр өссөн нь БШУ-ны сайдын 2022.11.23-ны “Журам батлах тухай” А/488 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын салбарын мэдээллийн систем

ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам"-ын хүрээнд Боловсролын ерөнхий газраас 2,273.8 мянган төгрөгийн үнэтэй 3 ш зөөврийн компьютер нийлүүлэгдсэн, аймгийн БШУГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, "Шимт боловсрол" ХХК-ийн захирал, Жаргалант сумын цэцэрлэгийн эрхлэгч нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ 2022.11.25-ний ШБ/22/33-тоот гэрээгээр олгогдсон санхүүжилтээс 2,000.0 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 464,822.0 мянган төгрөг болж 47,120.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 245 хүүхдийг хамруулахаар тооцон зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын санхүүжилтээр бүрэн санхүүжүүлэхээр нийт зарлагыг 655,561.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг 42,080.4 мянган, нормативт зардлыг 30,900.4 мянган, 387,305.4 мянган төгрөгөөр баталжээ.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативаар тооцож төсвийг хуваарилсан, төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн зардал, боловсролын байгууллагуудын ажилтнуудад улирал тутам олгодог үр дүнгийн урамшуулал олгох хэлбэр зэрэгт өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Тайлант хугацаанд тус цэцэрлэгийн төсвийн хуваарьт 2022 оны 12 дугаар сард өөрчлөлт орж, улсын төсвөөс авах санхүүжилтийг 415,583.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 46,532.0 мянган төгрөгөөр буюу нийт зарлагыг 462,115.0 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхэд 462,115.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 415,583.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 46,532.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагдсаныг бүрэн авсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт оруулсан байна.
БНА-2023/58/НА-СТА-ТШЗ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 408,028.6 мянган төгрөг буюу 88.3 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 1,456.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, улсын төсвөөс олгосон санхүүжилтээс 52,630.4 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71801- Сургуулийн өмнөх боловсрол	462,115.0	408,028.6	54,086.4	88.3
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	45,532.0	45,076.0	1,456.0	88.3
АРГА ХЭМЖЭЭ 81605- Эрүүл мэндийг дэмжих	1,500.0	1,500.0	0.00	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	48,873.1	46,528.8	2,344.3	95.0
АРГА ХЭМЖЭЭ 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,601.3	1,600.0	1.3	100
АРГА ХЭМЖЭЭ 81823- Боловсролын байгууллагын багш,	1,500.0	1,500.0	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 81834- Боловсролын стандарт, сургалт	324,973.4	282,923.5	42,049.9	87.0
АРГА ХЭМЖЭЭ 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	37,135.2	28,900.3	8,234.9	78.0

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн 15,983.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал.

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 49 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад анхны батлагдсан төсөвт зардлын 387,305.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,809.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 4,357,2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийн хүрээнд 462,115.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас батлагдсан төсвөөс нийт 54,086.4 мянган төгрөгийг хэмнэснээс хуульд хамаарах доорх зардлыг хэмнэж ажиллажээ.

- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын гүйцэтгэлд хяналт тавьж гүйцэтгэлээр санхүүжүүлснээс хоолны зардлаас 2,344.3 мянган төгрөгийг хэмнэсэн атлаа төсөвт төвлөрүүлээгүй
- Тогтмол зардлын санхүүжилтээс 1,455.4 мянган төгрөгийн хэмнэж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаатай холбоотой 42,469.2 мянган төгрөгийн 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 424,502.4 мянган төгрөгийн 24 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 21,460.7 мянган төгрөгийн 4 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 26,594.0 мянган төгрөгийн 8 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн эсэхийг шалгахад тендер шалгаруулах, худалдан авах ажиллагаатай холбоотой 39,765.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 12,619.9 мянган төгрөгийн 1 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцээгүй* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийссэн ба завсрын аудитаар зөрчил, дутагдал илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 104,827.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсний хэрэгжилтийн тайланг 2022.05.26-ний өдрийн 34 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Fas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	104,827.1	2	104,824.1	100
Нийт дүн	2	104,827.1	2	104,827.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5.Аудитын илрүүлэлт

Аудитаар хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрсэнд зөвлөмж өгөв.

5.1.Зөвлөмж

1. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний нийлүүлэгчийн нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 2022 оны 10,11, сарын 39765.0 мянган төгрөгийн, цалингийн зардлаас БНА-2023/58/НА-СТА-ТШЗ

Жаргалант сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10,11 сарын 12619.9 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6. хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний нийлүүлэгчийн нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 2022 оны 10,11, сарын 39765.0 мянган төгрөгийн, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10,11 сарын 12619.9 мянга, нийт 52384,9 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	52,384.9					1	52,384.9
Дүн	1	52,384.9	0	0	0	0	1	52,384.9

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---